



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/53/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг
2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.ТӨГСЖАРГАЛ ТАНАА
2020.02.28 № 1-6/2020 танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Н.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Төгсжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, өглөг, авлагын тооцоог барагдуулах, тооцоо нийлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ний захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сурагч нэг бүрийн хөгжлийг дэмжиж, ээлжит хичээлийг чанаржуулан, сурлагын чанарт ахиц гаргаж, эх хэлээрээ зөв ярьж бичдэг, эх оронч хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх”-д оршино.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна..

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ний “Acolous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 547,734.5 мянган төгрөгөөс тооцон 5,477.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,477.3 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,921.1 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	19,352.3	1,213.3	-18,139.0
Урьдчилгаа			
Бараа материал	40,128.4	42,466.0	2,337.5
Үндсэн хөрөнгө	1,568,133.6	1,532,014.0	-36,119.6
Нийт хөрөнгө	1,627,614.4	1,575,693.3	-51,921.1
Өр төлбөр	286.1	702.7	416.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,627,328.3	1,574,990.6	-52,337.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,627,614.4	1,575,693.3	-51,921.1

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд үүссэн байгууллагаас авах авлага барагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь барилгын сайжруулалт 22,618.5 мянган төгрөг, номын фондод 7,252.0 мянган төгрөг, тавилга эд хогшил дансанд 26,135.5 мянган төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэж авсан нь шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 34,087.3

мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 23,211.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1 хөтөлбөрт зориулан 492,542.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 492,542.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 393,060.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 99,482.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 489,789.3 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас 741.3 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлаас 1,287.7 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гарснаас шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,086.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,931.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 155.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч байна.

1. Сахилгын шийтгэл оногдуулсан 5 ажилтанд 1,931.5 мянган төгрөгийн үр дүнгийн шагнал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7.хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Аудитаар илэрсэн 155.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 125 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 76,557.0 мянган төгрөгийн зөрчилд 7,939.5 төлбөрийн акт тогтоосноос 7,939.5 мянган төгрөгийг барагдуулсан, 68,459.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 68,459.1 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагуудтай 155.0 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийн баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Харилцагч байгууллагууд авлага, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй, барагдахгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулан, баталгаажсан дүнг санхүүгийн тайланд тусгаж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,480,752.84	43,679,252.84
33	АВЛАГА	19,352,289.00	1,213,289.00
33500	Бусад авлага	19,352,289.00	1,213,289.00
33510	Байгууллагаас авах авлага	19,002,700.00	665,700.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	349,589.00	547,589.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,128,463.84	42,465,963.84
35100	Түүхий эд материал	17,893,647.84	17,893,647.84
35110	Тусгай зориулалттай материал	17,893,647.84	17,893,647.84
35400	Хангамжийн материал	20,464,816.00	22,822,316.00
35410	Бичиг хэргийн материал	129,500.00	163,600.00
35420	Аж ахуйн материал	17,116,916.00	18,918,416.00
35460	Хүнсний материал	2,086,500.00	1,609,300.00
35470	Бусад хангамжийн материал	1,131,900.00	2,028,000.00
35600	Мал амьтад	1,770,000.00	1,750,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,568,133,641.97	1,532,014,020.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,568,133,641.97	1,532,014,020.99
39200	Биет хөрөнгө	1,544,681,975.15	1,508,584,354.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,463,273,470.00	1,485,273,470.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,942,500.00	-43,613,399.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	103,536,010.31	108,256,010.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,153,424.74	-78,945,012.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,883,423.94	81,273,423.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,367,658.71	-52,963,900.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,426,460.00	4,426,460.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,449,687.22	-3,790,579.68
39217	Ном	8,475,881.57	8,667,881.57
39300	Биет бус хөрөнгө	23,451,666.82	23,429,666.86
39301	Програм хангамж	360,000.00	360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-334,333.18	-356,333.14
39303	Бусад биет бус хөрөнгө	23,426,000.00	23,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,627,614,394.81	1,575,693,273.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	286,090.36	702,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	286,090.36	702,700.00
41300	Өглөг	286,090.36	702,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	89,790.36	6,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,300.00	695,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,627,328,304.45	1,574,990,573.83
51	Засгийн газрын хувь оролцоо	1,627,328,304.45	1,574,990,573.83
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	667,016,792.49	667,016,792.49
51200	Хуримтлагдсан үр дүн	146,031,048.49	93,693,317.87
51210	Өмнөх үеийн үр дүн	106,799,320.27	146,031,048.49
51220	Тайлант үеийн үр дүн	39,231,728.22	-52,337,730.62
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	814,280,463.47	814,280,463.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,627,614,394.81	1,575,693,273.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	552,845,470.00	495,396,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,231,170.00	2,191,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,231,170.00	2,191,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,231,170.00	2,191,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,231,170.00	1,993,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	502,614,300.00	493,205,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,582,500.00	393,060,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	500,582,500.00	393,060,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,031,800.00	663,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,440,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	591,800.00	663,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	99,482,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	99,482,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	513,055,666.80	547,734,530.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,055,666.80	547,734,530.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,778,035.86	531,840,916.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,205,986.28	309,246,700.75
210101	Үндсэн цалин	190,835,702.28	229,744,801.20
210102	Нэмэгдэл	43,358,812.00	53,552,281.93
210104	Урамшуулал	23,011,472.00	25,949,617.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,185,949.46	37,690,054.40
210201	Тэтгэврийн даатгал	19,027,046.46	24,056,390.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,681,503.00	2,686,149.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,000,500.00	3,668,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	499,700.00	737,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,977,200.00	6,541,514.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,951,465.00	96,807,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,734,322.00	2,887,698.00
210302	Түлш, халаалт	89,840,395.00	91,630,070.00
210303	Цэвэр, бохир ус	2,376,748.00	2,289,432.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,555,088.00	6,266,905.00
210401	Бичиг хэрэг	1,273,000.00	2,005,300.00
210402	Тээвэр, шатахуун	932,000.00	1,013,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	643,788.00	618,955.00
210404	Ном, хэвлэл	33,000.00	16,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	751,000.00	614,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	922,300.00	1,998,950.00
2105	Нормативт зардал	9,331,900.00	8,992,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,250.00	121,600.00
210502	Хоол, хүнс	9,124,650.00	8,871,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,694,770.60	3,169,035.00

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	14,694,770.60	3,169,035.00
2107	Томилолт, зочны зардал	701,400.00	1,737,900.00
210702	Дотоод албан томилолт	701,400.00	1,737,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,557,800.00	720,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,557,800.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,593,676.52	67,210,520.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	529,920.00	30,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,045,100.00	1,758,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,018,656.52	65,421,620.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,277,630.94	15,893,614.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,599,800.00	13,140,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,144,600.00	12,340,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,954,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,400,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2,450.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,450.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,677,830.94	2,750,964.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,677,830.94	2,750,964.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	39,789,803.20	-52,337,730.62
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	558,074.98	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	558,074.98	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,231,728.22	-52,337,730.62

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	502,738,800.00	493,205,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	502,738,800.00	493,205,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,582,500.00	492,542,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	99,482,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	500,582,500.00	393,060,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,156,300.00	663,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,440,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	716,300.00	663,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488,919,800.00	482,903,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,919,800.00	482,903,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,642,169.06	466,347,185.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,606,055.38	309,335,791.11
210101	Үндсэн цалин	190,235,771.38	229,833,891.56
210102	Нэмэгдэл	43,358,812.00	53,552,281.93
210104	Урамшуулал	23,011,472.00	25,949,617.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,908,079.68	37,690,054.40
210201	Тэтгэврийн даатгал	19,749,176.68	25,063,210.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,681,503.00	2,546,149.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,000,500.00	3,118,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	499,700.00	617,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,977,200.00	6,344,695.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,834,431.00	96,271,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,734,322.00	2,887,698.00
210302	Түлш, халаалт	90,463,745.00	91,006,302.00
210303	Цэвэр, бохир ус	2,636,364.00	2,377,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,889,888.00	4,061,755.00
210401	Бичиг хэрэг	855,500.00	559,800.00
210402	Тээвэр, шатахуун	932,000.00	1,116,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,588.00	618,955.00
210404	Ном, хэвлэл	87,200.00	16,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	845,600.00	1,210,800.00
2105	Нормативт зардал	9,550,200.00	9,282,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	215,950.00	121,600.00
210502	Хоол, хүнс	8,061,250.00	8,393,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,273,000.00	767,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,198,095.00	3,208,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	483,000.00	0.00
210604	Урсгал засвар	30,715,095.00	3,208,850.00
2107	Томилолт, зочны зардал	701,400.00	1,737,900.00
210702	Дотоод албан томилолт	701,400.00	1,737,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,033,900.00	760,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,033,900.00	760,000.00

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний төлбөр хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,920,120.00	3,998,935.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,004,920.00	199,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,915,200.00	3,799,935.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,277,630.94	16,556,614.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,599,800.00	13,140,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,144,600.00	12,340,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,954,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,400,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	665,450.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	665,450.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,677,830.94	2,750,964.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,677,830.94	2,750,964.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,819,000.00	10,302,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,819,000.00	10,302,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,819,000.00	10,302,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,819,000.00	10,302,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,819,000.00	10,302,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,819,000.00	-10,302,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	643,590,792.49	426,490,115.00	106,595,540.27	1,176,676,447.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	203,780.00	203,780.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	643,590,792.49	426,490,115.00	106,799,320.27	1,176,880,227.76
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	387,790,348.47	0.00	387,790,348.47
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	23,426,000.00	0.00	0.00	23,426,000.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	39,231,728.22	39,231,728.22
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,016,792.49	814,280,463.47	146,031,048.49	1,627,328,304.45
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	667,016,792.49	814,280,463.47	146,031,048.49	1,627,328,304.45
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,016,792.49	814,280,463.47	146,031,048.49	1,627,328,304.45
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-52,337,730.62	-52,337,730.62
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,016,792.49	814,280,463.47	93,693,317.87	1,574,990,573.83

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	492 542 800.00	489 789 385.51	2 753 414.49	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492 542 800.00	489 789 385.51	2 753 414.49	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478 827 800.00	476 649 185.51	2 178 614.49	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310 077 100.00	309 335 791.11	741 308.89	99.8
210101	Үндсэн цалин	229 833 900.00	229 833 891.56	8.44	100.0
210102	Нэмэгдэл	53 552 300.00	53 552 281.93	18.07	100.0
210104	Урамшуулал	26 690 900.00	25 949 617.62	741 282.38	97.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 977 800.00	37 690 054.40	1 287 745.60	96.7
210201	Тэтгэврийн даатгал	25 676 300.00	25 063 210.38	613 089.62	97.6
210202	Тэтгэмжийн даатгал	2 660 300.00	2 546 149.00	114 151.00	95.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 325 400.00	3 118 100.00	207 300.00	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	665 100.00	617 900.00	47 200.00	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6 650 700.00	6 344 695.02	306 004.98	95.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96 271 400.00	96 271 400.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2 945 700.00	2 887 698.00	58 002.00	98.0
210302	Түлш, халаалт	90 948 300.00	91 006 302.00	-58 002.00	100.1
210303	Цэвэр, бохир ус	2 377 400.00	2 377 400.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4 396 000.00	4 363 755.00	32 245.00	99.3
210401	Бичиг хэрэг	300 000.00	564 600.00	-264 600.00	188.2
210402	Тээвэр, шатахуун	1 130 000.00	1 116 200.00	13 800.00	98.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 000 000.00	618 955.00	381 045.00	61.9
210404	Ном, хэвлэл	406 000.00	203 200.00	202 800.00	50.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760 000.00	540 000.00	220 000.00	71.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800 000.00	1 320 800.00	-520 800.00	165.1
2105	Нормативт зардал	9 380 200.00	9 282 500.00	97 700.00	99.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	216 000.00	121 600.00	94 400.00	56.3
210502	Хоол, хүнс	8 394 200.00	8 393 800.00	400.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770 000.00	767 100.00	2 900.00	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10 211 300.00	10 208 850.00	2 450.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7 000 000.00	7 000 000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3 211 300.00	3 208 850.00	2 450.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	1 750 000.00	1 737 900.00	12 100.00	99.3
210702	Дотоод албан томилолт	1 750 000.00	1 737 900.00	12 100.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 760 000.00	3 760 000.00	0.00	100.0

Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 760 000.00	3 760 000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4 004 000.00	3 998 935.00	5 065.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	204 000.00	199 000.00	5 000.00	97.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 800 000.00	3 799 935.00	65.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 715 000.00	13 140 200.00	574 800.00	95.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	13 715 000.00	13 140 200.00	574 800.00	95.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12 915 000.00	12 340 200.00	574 800.00	95.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800 000.00	800 000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	492 542 800.00	489 789 385.51	2 753 414.49	99.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	393 060 100.00	390 309 135.51	2 750 964.49	99.3
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	393 060 100.00	390 309 135.51	2 750 964.49	99.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99 482 700.00	99 480 250.00	2 450.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	99 482 700.00	99 480 250.00	2 450.00	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	286	286	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	10	10	0.00	100

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		663,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		663,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		663,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		663,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		663,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.25	Аудитын нэр: Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2020/53/-СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн Өргөн сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнэ болон ашиглагдах жилийг шинэчлэх	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	С.Баатарсүрэн
2	Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн тооцоо хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна	155.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	С.Баатарсүрэн
3	Сахилгын шийтгэл оногдуулсан 5 ажилтанд 1,931.5	1,931.5	Төлбөрийн акт	Нягтлан бодогч	С.Баатарсүрэн